



СОЁМБО

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

МЭДЭЭ

№251 /460/

Цаг үе, үйл явдал

ЭНХИЙГ САХИУЛАГЧДЫН ГАВЬЯАГ ҮНЭЛЖ, ТӨРИЙН ОДОН, МЕДАЛИАР ШАГНАВ



Өнөөдөр Соёлын төв өргөөнд Бүгд Найрамдах Өмнөд Судан Улсад явагдаж буй НҮБ-ын мандаттай энхийг сахиулах "UNMISS" ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн Монгол Улсын Зэвсэгт хүчний мотобуудлагын батальоны XXI ээлжийн бие бүрэлдэхүүнд төрийн одон, медаль, Батлан хамгаалах салбарын шагнал гардуулах ёслолын ажиллагаа боллоо.

Ёслолын ажиллагаанд Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүх, Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга Ж.Энхбаяр, Ерөнхийлөгчийн Аюулгүй байдал, Батлан хамгаалах бодлогын зөвлөх дэслэгч генерал Ц.Тогоо, БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга бригадын генерал Д.Ганхуяг, ЗХЖШ-ын дарга бригадын генерал С.Ганбямба,

Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч бригадын генерал Ж.Болдбаатар, ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга хурандаа Ж.Өсөхбаяр, орлогч дарга хурандаа Т.Галбадрах болон Зэвсэгт хүчний Төрлийн цэргийн командлагч нар, Барилга-инженерийн удирдах газрын дарга, үүргээ амжилттай гүйцэтгэсэн энхийг сахиулагчид оролцлоо.

Монгол Улсын Зэвсэгт хүчин НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын цэргийн ажиллагаанд 2002 оноос эхлэн оролцож эхэлснээс хойш өдгөө давхардсан тоогоор 21000 орчим цэргийн алба хаагч, түүний дотор 1000 гаруй эмэгтэй цэргийн алба хаагч үүргээ нэр төртэйгөөр гүйцэтгэн, өнөөдрийн байдлаар дэлхийн цэрэг хандивлагч орнуудаас 23 дугаарт эрэмбэлэгдэж байна. Цэргийн гавьяаны одонгоор UNMISS ажиллагааны Хүчний штабын удирдах албан тушаалд үүрэг

гүйцэтгэсэн хурандаа О.Нацагдорж нарын зургаан алба хаагчийг, Цэргийн хүндэт медалиар цэргийн багийн ажиллагааны удирдлага, өдөр тутмын үйл ажиллагааг чадварлаг зохион байгуулсан дэд хурандаа Н.Гэрэлбадрах нарын 17 алба хаагчийг, Энхийн төлөө медалиар энхийг сахиулах ажиллагаанд анх удаагаа оролцож, томилгоот үүргээ амжилттай биелүүлсэн ахмад Б.Хишигсүрэн, ахлах ахлагч Г.Октябрь, дэд ахлагч П.Мөнхсаран нарын 417 алба хаагчийг шагналаа.

Мөн Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайдын тушаалаар БНӨСУ улсад цаг агаарын, үер усны гамшиг болон цагийн байдлын хүнд нөхцөлд энхийг сахиулах үүргээ нэр төртэй гүйцэтгэсэн цэргийн алба хаагчдад Батлан хамгаалах салбарын шагналыг гардуулж баяр хүргэлээ.

Дэслэгч Т.ИДЭР

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-16	-31

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
39	25

ВАЛҮТЫН ХАНШ


ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3.484	3.488
EUR	3.788	3.805
CNY	512	514
RUB	49	49.50
JPY	27.10	27.30
KRW	2.86	2.90

ЗУРХАЙ

2022.01.20 / БААСАН ГАРАГ /
БИЛГИЙН ТООЛЛЫН 28

ӨВЛИЙН ДУНД ХАР ХУЛГАНА
САР
ТАВАН ШАР МЭНГЭТЭЙ ШАР
БАР ӨӨР

Үс засуулбал:
Хэрүүл тэмцэл ирнэ
Наран ургах, шингэх:
08.33-17.33
Барилдлага:
Идэр
Шүтэн барилдлага:
Авахуй



Г.МЯГМАРЖАВ: “ТЭМҮҮЖИН ӨРЛӨГ” ДУНД СУРГУУЛИЙН ТӨГСӨГЧИД МЭРГЭЖИЛ БОЛОН БИЕ БЯЛДРЫН ХУВЬД ӨНДӨР ТҮВШИНД БЭЛТГЭГДСЭН БАЙДАГ



Батлан хамгаалахын сайдын дэргэдэх “Иргэний зөвлөл”-ийн гишүүн, “Оюутан цэрэг” хөтөлбөрийн ерөнхий зохицуулагч, Ардын багш, Монгол Улсын Гавьяат багш, доктор (Sc.D), профессор Г.Мягмаржав ҮБХИС-ийн “Тэмүүжин Өрлөг” дунд сургуулийн багш нарт “Багш мэргэжил сайхан” сэдвээр яриа хийлээ.

Энэ үеэр Ардын багш, Монгол улсын гавьяат багш, доктор (Sc.D), профессор Г.Мягмаржав хэлсэн үгэндээ “Батлан хамгаалахын сайдаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу тус сургуулийн үйл ажиллагаатай танилцахын зэрэгцээ багш нарын мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор өөрийн туршлага сургамжаас хуваалцлаа. “Тэмүүжин Өрлөг” дунд сургуулийг дүүргэж ЦНДС-д элсэж цэргийн алба хаагч болж буй залуусыг харахад эх оронч үзэл хандлага, биеэ авч явах байдал, цэргийн мэргэжил болоод

бие бялдрын бэлтгэлжилтийн хувьд өндөр түвшинд бэлтгэгдсэн байдаг нь бэлхнээ харагддаг. Тухайлбал, 2022 оны “Оюутан цэрэг” хөтөлбөрт уг сургуулийн зарим төгсөгчид ажилласан бөгөөд тэр хугацаанд алдаа дутагдалгүй, үлгэр жишээч байдлаараа бусад нөхдөө манлайлж чадсан. Орчин цагийн Монгол Улсын Зэвсэгт хүчин мэргэжлийн цэрэгт суурилсан чадварлаг боловсон хүчинтэй болох тэргүүн зорилгыг тавин ажиллаж байгаа. Харин үүнд хүрэхэд тус дунд сургууль үндэс суурийг нь цутгагч нь болно гэж харж байна” гэлээ.

“Тэмүүжин Өрлөг” дунд сургуулийн удирдлага, хамт олон нь бие даасан байдлаа хөгжүүлж, багш суралцагчдын ая тухтай ажиллах, суралцах орчин нөхцөлөө сайжруулж, сургалтын чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр үр бүтээлтэй ажилласнаар 2021 онд “Нийслэлийн тэргүүний сургууль”-иар шалгарчээ.



КОРОНАВИРУС
ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол
Нийт: 672,660,856

Эдгэрсэн
Нийт: 644,116,658

Нас барсан
Нийт: 6,740,264

Цахим шууданд

ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ЯВУУЛЛАА

ХӨХ МӨНХ ТЭНГЭР НЬ ЦЭЛМЭГ ХӨӨРӨЛТ БУУЛТЫН ТОО ТЭНЦҮҮ БАЙГ



Ми-171Е загварын нисдэг тэрэгний нисэх багийн даргаар УБ-Минж-УБ чиглэлд бие даасан нислэгээ осол зөрчилгүй хийж гүйцэтгэлээ. Залуу багш нисгэгч, нисэх багийн дарга хоёрын маань багш нар нь болох багш нисгэгч хурандаа Н.Очирбат, МУ-н гавьяат нисгэгч, шалгагч, багш нисгэгч хурандаа Н.Баясгалан нар шавь нарынхаа бие даасан нислэгийг сэтгэл доглон хүлээж, үүргээ амжилттай биелүүлээд ирсний дараа баяр

бахдалаар дүүрэн халуун тэврэлтээр баяр хүргэлээ. Мөн амжилттай нислэг үйлдсэн нисгэгчид, инженер техникийн бүрэлдэхүүнд ангийн удирдлагын зүгээс баяр хүргэж, тус ангийн онцгой, тусгай үүргийн болон сургууль дадлагын нислэгийг цаг агаарын хүндэрсэн болон ердийн нөхцөлд тасралтгүй нэр төртэйгөөр гүйцэтгэж байгаад талархал илэрхийллээ. **АГААРЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАЛ**

Зэвсэгт хүчний Тээврийн хяналтын албанаас Улаанбаатар цэргийн хүрээний анги байгууллагуудад сургалт болон шалгалтуудыг зохион байгуулж байна.

Тухайлбал, Тээврийн хяналтын албанаас зам тээврийн осол зөрчил, ажлын байрны архидалт, цахим гэмт хэрэг зэрэг гэмт хэргийн гаралт түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх

талаар нийт бие бүрэлдэхүүнд мэдээлэл өгсний зэрэгцээ анги байгууллагуудын өдөр тутмын үйл ажиллагаанд гардаг авто машинуудын бэлэн байдал, граш, тавилангуудын аюулгүй байдал зэрэгт хяналт шалгалт явуулж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж зөвлөмж, зөвлөгөө өгч ажиллав.

ТЭЭВРИЙН ХЯНАЛТЫН АЛБА

Зэвсэгт хүчний 303 дугаар ангийн захирагчийн нислэг эрхэлсэн орлогч хошууч Ж.Батжаргал Ми-171Е загварын нисдэг тэрэгний багш нисгэгчээр, нисдэг тэрэгний хэсгийн захирагч ахмад Э.Дэмбэрэлсамбуу



Цаг үе, үйл явдал

БАЙЛДАГЧ Л.БУЯННЭМЭХ: МЭРГЭЖЛИЙН СЭТГЭЛ ЗҮЙЧИЙН ХУВЬД ОНЖАВУУДДАА СУРГАЛТ ЯВУУЛДАГ



Зэвсэгт хүчний зарим нэгтгэл, ангиуд “Байлдагчаас байлдагчид” гэдэг зарчмаар амралтын өдрүүдэд соёл хүмүүжил, сургалтын арга хэмжээг дотооддоо зохион байгуулсаар байгаа билээ. Энэ нь англи хэл, хөгжмийн боловсрол, мужаан, илтгэх урлаг, сэтгэл зүй зэргээр суралцаж төгсөж, ажлын байран дээр дадлагажсан хугацаат цэргийн алба хаагчийг сургагч багшаар томилон бусад нөхдөдөө заахад нь дэмжлэг үзүүлдэг гэсэн үг юм. Зэвсэгт хүчний 120, 326 дугаар ангиуд 2021-2022 онд цэргийн сургалт бэлтгэлийн бус цагаар энэхүү сургалт, нөлөөллийн арга хэмжээг амжилттай хэрэгжүүлсэн юм.

Энэ жишгээр Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн хугацаат цэргийн алба хаагч, байлдагч Лхагвадоржийн Буяаннэмэх онжавууддаа гэр бүлийн үнэ цэн, хувь хүний хөгжил сэдвээр амралтын өдөр бүр сургалт явуулдаг ажээ. Тэрээр мэргэжлийн сэтгэл зүйч бөгөөд энэ чиглэлээрээ хэдэн байгууллагад ажиллаж байсан залуу юм. Түүнтэй ярилцсанаа хүргэе. -Эрхэм байлдагч та өөрийгөө

танилцуулахгүй юу? -1998 онд төрсөн, одоо 25 настай. Ангидаа онжавуудаасаа хамгийн ахмад нь. Аавыг С.Лхагвасүрэн, ээжийг Б.Бийнаа гэдэг, тэд маань Налайх дүүрэгтээ ажиллаж амьдарч байна. Эхээс тавуулаа. Би 2004-2016 онд нийслэлийн Налайх дүүргийн ерөнхий боловсролын “Эрдэм-Оргил” цогцолбор сургуулийг төгсөж, 2016-2020 онд олон улсын “Улаанбаатар” дээд сургуулийг сэтгэл зүйч, социологич мэргэжлээр дүүргэсэн. Төгсөөд ММCG судалгааны байгууллагад судлаач, социологич, “Өнөр бүл” хүүхэд асран хүмүүжүүлэх төвд нийгмийн ажилтан хийж байлаа. Дараа нь веб дизайнераар суралцаж, энэ төрлийн хувийн байгууллагад ажиллаж байгаад цэргийн албанд ирсэн юм.

-Мэргэжлээрээ явуулдаг сургалтынхаа тухайд?

-Ангийн захирагч “Манай Буянаа мэргэжлийн сэтгэл зүйч хүн байна. Хувь хүний хөгжил сэдвээр онжавууддаа сургалт явуулбал яаж байна. Байлдагч байлдагчаасаа илүү сайн

суралцдаг тал бий” гээд бүх талын дэмжлэг үзүүлсэн. Бямба гаригт “Гэр бүлийн үнэ цэн”, ням гаригт “Хувь хүний хөгжил” гэсэн ерөнхий агуулгын хүрээнд дэд сэдвүүдээр хувааж сургалтаа явуулдаг. Онжавууд маань ч идэвхтэй хамрагдаж, сургалтын дараа асуулт тавихад нь баярладаг шүү.

Ялангуяа, цэргийн алба хаах үедээ өөрийгөө хэрхэн дайчилж суралцах, юу сурах ёстой тэр бүрийг нь яаж өөрийн болгох вэ гээд урам зориг, эрч хүч өгөх талд нь илүү анхаардаг. Зарим тохиолдолд сэтгэл зүйн зөвлөгөө ч өгнө. Манай онжавуудын хувьд гэхдээ сэтгэл зүйн хүндрэлтэй асуудал ер нь бол байхгүй. Ярилцахад л мэдрэгддэг” гэж хариулав.

Байлдагч Л.Буяаннэмэх нь мэргэжлээсээ гадна илтгэх урлагаар хичээллэж, гитар тоглож, төсөл бичих сонирхолтой гэнэ. Цэргийн албанд ирснээр сонирхлуудаа бодит ажил болгон үеийн нөхдөдөө зааж туршлага хуримтлуулж буйдаа тэр сэтгэл хангалуун байна.

Гэрэл зургийн сурвалжилга



ЭНХ ЦАГИЙН ЭГЭЛ БААТРУУДДАА ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭВ

